



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 04 сарын 09 өдөр

Дугаар А/207

Номгон

Баянхонгор аймгийн Баян-Өндөр,
Баянговь, Баян-Овоо сумдын хот суурин газрын
хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хүлээн авах
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2025 онд хийгдсэн Баян-Өндөр, Баянговь, Баян-Овоо сумдын хот суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хүлээж авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

Г.Энхбаяр

Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Ажлын хэсгийн гишүүд:

П.Саруулцэцэг

Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Ерөнхий архитектор

Т.Бямбадорж

Баян-Овоо сумын Засаг дарга

Б.Далай

Баян-өндөр сумын Засаг дарга

В.Батжаргал

Баянговь сумын Засаг дарга

А.Цэцэнбилэг

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Удирдлагын хэлтсийн дарга

Э.Батчимэг

Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга:


Х.Сонинбаяр

Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

626010846

2.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2025 онд хийгдсэн Баян-Өндөр, Баянговь, Баян-Овоо сумдын хот суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Архив албан хэрэг хөтлөлтийн тухайн хуулийн дагуу бүрдүүлж хүлээн авах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулж ажиллахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Наранбаяр)-д даалгасугай.

ДАРГА  Ө.ЭНХБАТ